



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
хойшлуулах тухай**

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.3, 69.6 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.9, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.5, 7.3.22 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийн тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар тогтоолоор 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр товлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хойшлуулсугай.
2. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 09:00 цагт Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газар II байр Д корпуст зохион байгуулсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - а. Нэмэлт хувьцаа гарган олон нийтэд санал болгох тухай
4. Компанийн хойшлогдсон ээлжит бус хурлын зарыг энэ тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталж нийтэд мэдээлэх өдрийг хурал хуралдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтыг энэ тогтоолын Хавсралт №2-т зааснаар баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.СҮХ-ОЧИР

“МХБ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны
өдрийн 25 дугаар тогтоолын Хавсралт №1



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК
Хаяг:	Сүхбаатар талбай-3, Улаанбаатар 15160, Монгол Улс
Хурал хуралдах өдөр, цаг:	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 09:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Монгол Улсын Сангийн Яам, С.Данзангийн гудамж, Засгийн газар II байр Д корпус, Улаанбаатар хот
Хурлын төрөл:	Ээлжит бус
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гарсан огноо:	ТУЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Тогтоол №25
Баримт бичгийн жагсаалт/ хавсралтаар/:	1. Хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол 2. Нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох тухай хувьцаа эзэмшигчийн шийдвэрийн төсөл
Баримт бичгийн хуудасны тоо:ширхэг
хуудас

“МХБ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны
өдрийн 25 дугаар тогтоолын Хавсралт №2



**КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ
АСУУДАЛТАЙ ХОЛБОГДСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ
БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ**

1. Хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
2. Нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох тухай хувьцаа эзэмшигчийн шийдвэрийн төсөл